



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 36

Номгон

Төрийн жинхэнэ албан хаагчийг тангараг
өргүүлэх арга хэмжээ зохион байгуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 84 дүгээр зарлигийн хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын 2.1, 2.2, 2.3 дахь заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

1.Төрийн жинхэнэ албан хаагчийг тангараг өргүүлэх арга хэмжээг “Улс тунхагласны баярын өдөр” буюу 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсугай.

2.Төрийн захиргааны албан тушаалд анх удаа, хууль ёсны дагуу, жинхлэн томилогдсон төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх эрх үүссэн албан хаагчдыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3.Зохион байгуулах ажлын хэсгийг 2 дугаар, хөтөлбөрийг 3 дугаар, хавсралтаар тус тус баталсугай.

4.Тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг чанартай гүйцэтгэж, тайланг хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэг (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ